



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2016 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/16

Өлгий

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "а" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэнгэл сумын МАА-ын өвөлжилтийн байдалтай танилцаж багийн иргэдийн санал хүсэлтийг сонсож, зохих хууль тогтоомж болон төр, аймаг орон нутгаас авч хэрэгжүүлж байгаа ажлын талаар мэдээлэл өгөх холбогдох газруудад уламжлах, газар нутаг бэлчээрийн маргаантай асуудлыг газар дээр нь шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байуулсугай.

|                       |              |   |
|-----------------------|--------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч. | Ж.Естай      | -Аймгийн ГХБХБГ-ын ГУХ-ийн дарга        |
| Гишүүд:               | Х.Алдаберген | -Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн |
|                       | Б.Нургулан   | -Аймгийн ХХААГ-ын МЭХ-ийн дарга         |
|                       | К.Самархан   | -Аймгийн ХХҮГ-ын дэд дарга              |
|                       | Ж.Ергазы     | -Цэнгэл сумын хэсгийн төлөөлөгч, ахмад  |

2.Тус сумын өвөлжилтийн байдалд дүгнэлт хийж, зудын зэрэглэл тогтоож, иргэдээс гаргасан санал хүсэлтийг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг /Ж.Естай/-д даалгасугай.

